

БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ

БАТЛАВ
КОНВИШН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.СОНИНПИЛ

КОВШ МАШИНЫ ПАЛЫЦ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 116/2022

20²² оны 10-р сарын 24

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас Конвишн ХХК-ийг төлөөлж захирал Б.Сонинпил /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “Ковш машины пальц” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1. Энэ гэрээний нийт үнэ 8,900,001 /найман сая есөн зуун мянга нэг/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 30 /гуч/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5011597892 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн АХММХМ инженер Н.Сайнбилэг хариуцан ажиллана. Утас- 98109919.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Конвишн ХХК-ийн захирал Б.Сонинпил хариуцан ажиллана. Утас-88039141

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэх, хэмхэрэхээс хамгаалсан сав, баглаа боодолтой, шинэ байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1. Нийлүүлэгчийн ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 5 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.
- 8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 5 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

 Ө.УДВАЛ

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ЭРДЭНЭБИЛЭГ


АХММХМ ИНЖЕНЕР



Н.САЙНБИЛЭГ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ



ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ш.АМИНЖАРГАЛ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

КОНВИЗИН ХХК-ИЙН

ЗАХИРАЛ



Б.СОНИНПИЛ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг 17-р хороо
1-р хороолол 32-55 тоот
Утас: 88039141
РД: 5583438



Хүчинтэй хугацаа Харилцагч Боловсруулсан		Эхлэх: 2022.10.20		Дуусах: 2022.11.10		
		Амгалан дулааны станц ТӨХК		Нэр	Амгалан дулааны станц ТӨХК	
		Конвишн ХХК		Утас	77111251	
			Веб хаяг			
			Нэр	Б.Сонинпил		
			Утас	88039141		
			И-мэйл	convision.ltd@gmail.com		
БАРААНЫ ҮНИЙН САНАЛ						
№	Бараа	Марк	Нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	50 ковшны шанганы цилиндр палыц		ш	2	4,045,455	8,090,910
	Дүн					8,090,910
	НӨАТ 10%					809,091
	Нийт дүн					8,900,001

Тайлбар: Дээрх бараан нь манайд бэлэн байхгүй бөгөөд захиалгаар нийлүүлнэ.

/Жич: Захиалгаар авсан тохиолдолд захиалгын хугацаа 30 хоног байна./



Захирал:

Б.Сонинпил

.....Тоот гэрээний хавсралт

НИЙЛҮҮЛЭХ БАРАА МАТЕРИАЛЫН ҮНИЙН ЖАГСААЛТ

№	Бараа материалын нэрс	Марк тип	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	50 ковш машины шанганы цилиндр пальц	/XGNA/117см/ R19	КОМ	2	4,045,455	8,090,910
2	НӨАТ 10%					809,091
	Дүн					8,900,001

Амгалан дулааны станц ТӨХК-ийн
АХММХМ инженер

Н.Сайнбилэг

Н.Сайнбилэг

Конвишн ХХК-ийн
Захирал



Б.Сонинпил